

ТАРАГТ СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН 2019 ОНЫ

1-3-Р САРЫН ТАЙЛАН

2019.03.22

1. БАГШИЙН МЭРГЭЖИЛ ДЭЭШЛҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР СУРГАЛТ СЕМИНАРТ ХАМРАГДСАН БАЙДАЛ

1.1 Багшийн мэргэжил дээшлүүлэх үндсэн сургалтад нийт 12 багш бүртгэгдсэнээс 10 жилийн сургалтад 4 багш, 5 жилийн сургалтад 3 багш, эхний жилийн сургалтад 5 багш, Одоогийн байдлаар 6 багш, сургалтад хамрагдах багш ажилтны 50% үндсэн сургалтад амжилттай хамрагдсан.

1.2 Хими-Биологийн багш С.Оюун-Эрдэнэ, ББМС М.Нарангэрэл нар УБ-Хотод “Тогтвортой хөгжлийн бодлого”-төслийн хаалтанд тайлан тавьж, туршлага судалсан

1.3 Өвөрхангай аймагт Бага ангийн “Багшийн арга зүй” үзүүлэх хичээлд бага ангийн багш Н.Бямбадолгор хамрагдан туршлага судласан.

1.4 2019 оны 1-р сарын 17-19-ны өдрүүдэд 2 менежер аймгийн БСУГ, Боловсролын үнэлгээний төвтэй хамтран зохион байгуулсан “Хөтөлбөрт суурилсан даалгавар боловсруулар арга зүй”-сургалтанд хамрагдаж ирээд арга зүйгээ түгээн дэлгэрүүлсэн.

1.5 Нийгмийн ажилтан Д.Эрдэнэчулуун Улаанбаатар хотод 01-р сарын 17-20ны өдрүүдэд чадавхжуулах сургалтанд хамрагдан Нийслэлийн гадаад хэлний гүнзгийрүүлсэн сургалттай 48-р сургуулийн болон “Ид шидийн орон хүүхэд хамгаалалын төвийн үйл ажиллагаатай танилцан туршлага судалсан .

1.6 Арвайхээр суманд явагдсан “Хүүхэд хөгжил хамгаалал”-ын зорилтот жилийн хаалтын болон “ Тохижилт ногоон байгууламжыг нэмэгдүүлэх “ зорилтот жилийн ажлын нээлтийн үйл ажиллагаанд оролцсон

- **“Удирдлага зохион байгуулалтын талаар:**

1.7 Бүсийн хэмжээнд
багаангийнбагшнархяналтшинжилгээхийсэншалгалтынмөрөөр багш нарт ажлын чиглэл өгч, гүйцэтгэн сайжруулах төлөвлөгөө гарган зөвлөн ажиллаж байна. Бага ангийн багш нар ЗАН-ийн цагаараа хамтран тоо бодох,зөв бичгийн дүрэм судлах зэрэг багш нар ажлын байрандаа хамтран хөгжих төлөвлөгөө гарган ажиллаж байна.

1.8 “Гамшгаас хамгаалах” төлөвлөгөөг боловсруулж баталгаажуулан

төлөвлөгөөний дагуу ажлуудыг зохион байгуулан ажиллаж байна.

1.9 100 хүүхдийн шинэ дотуур байрыг хүлээн авч нээлтийн үйл ажиллагааг амжилттай зохион байгуулсан.

1.10 Сургууль дээр хэрэгжиж буй үндэсний болон дэд хөтөлбөрүүдийн төлөвлөгөөг боловсрууллаа.

1.11 Багш нар 3-р улирлын хичээлийн хөтөлбөр төлөвлөгөөг боловсруулан баталгаажуулсан.

1.12 Орон нутгийн хөгжлийн сангийн нийтийн сонголд хамт олноороо оролцож, 2018 онд хийгдсэн ажлуудын тайлан, 2019 онд хийгдэх ажлын жагсаалтуудтай танилцаж, 2020 онд хийх ажлын саналд: 1. Сургуулийн үүдний талбай, шат 2.Сургууль, дотуур байрын нэгдсэн хашаабарих зэрэг саналуудыг нэн шаардлагатайгаар нь эрэмблэн хамт олноороо саналаа өгч, баталгаажуулсан.

1.13 12-р ангийн сурагчдыг багш нарын зөвлөгөөний хурлаар оруулж, суралцагч тус бүрт сурган хүмүүжүүлэх зөвлөгөө өгч, хичээл сонголт болон мэргэжил сонголтын талаар хэлэлцүүлэг зохион байгууллаа.

1.14 12-р ангийн сурагчдаас мэргэжлийн багш нар 7 хоног бүр , Сургалтын менежер, АУБ Н.Баярдолжинтой хамтарч 14 хоногт 1 удаа хөндлөнгийн шалгалт авч, ахиц, бууралтыг тодорхойллоо.

1.15 БСУГ-аас 12-р ангиас МХБ-ийн эрхийн шалгалтыг 2 удаа зохион байгуулж сурагчдын түвшин ахицыг тооцлоо. Эхний удаа сургуулиараа 25 сургуулиас 11-р байранд орж 2 хүүхэд босго оноонд хүрээгүй 87% ийн гүйцэтгэлтэй байсан бол 2 дахь шалгалтад 7-р байранд орж 100% -ийн гүйцэтгэлтэй шалгагдаж өмнөхөөс 2,6-16,6% иар ахисан үзүүлэлтэй байна.

1.16 Хичээлийн цагаар гар утас хэрэглэхгүй байх тал дээр багш, сурагчдыг хэвшүүлж, хяналт тавьж ажилласан.

1.17 Багш бүр 7 хоногийн 4 дэх өдөр хууль, шинээр хэрэгжиж буй тогтоол шийдвэрээр сургалт зохион байгуулж хэвшээд байна. “Хууль судлах өдөр”-тэй болсон. 7 удаагийн сургалт, 3 удаагийн мэдээлэл хийж 1 удаа шалгалт авч анализ дүгнэлт хийсэн.

1.18 Гар утасны хэрэглээний хорт зуршлын талаар 3 удаагийн сургалт зохион байгуулж, багш, сурагчид зөв дадал хэвшилд суралцацгааж байна.

1.19 Сумын хүүхдийн эрхийн ажилтанд ХӨУБ-ын 1 сургууль 10 клубийн үйл ажиллагааны чиглэл сурагчдын хамрагдалтын судалгаа болон эрсдлийн судалгааг нэгтгэж явуулсан

1.20 Мэргэжлийн хяналтын төлөвлөгөөт шалгалт 2019-2013 оны 03 сарыг 11-13 –ны өдрүүдэд сургууль дээр ажиллан сургалтын орчин, эрүүл ахуй, сургалтын стандартад хяналт шалгалт хийлээ. Үүнд бага боловсролын хүрээнд сургалтын орчин хангалттай сайн шалгагдлаа. Хичээлийн стандартын 5-р ангийн математик, 4-р ангийн монгол хэлний хичээлээр авахад 5-р анги 75,3%, 4-р анги 60% тай нийт дундаж 66,3 % тай үнэлэгдлээ.

1.21 Багш нарын ажлыг үнэлэх улирлын мөнгөн урамшуулал олгох шалгуур үзүүлэлтийг шинэчлэн 14 үзүүлэлт 53 шалгуур оноог нарийвлан гаргаж баталгаажуулан бага ангийн 5 багшийн ажлыг шалгуурын дагуу үнэллээ.

1.22 -Боловсролын мэдээлийн системд шаардлагатай мэдээ судалгааг тухай бүр нь шивж байгаа.

1.23 Боловсролын шинэчлэл-IV тэтгэгэлэлт төслийн хүрээнд “Хэлц үгээр дамжуулан сурагчдын унших, бичих, ярих чадварыг хөгжүүлэх нь”, “Бага ангийн сурагчдын сэтгэх чадварыг сайжруулах нь” гэсэн 2 төслийг бичин БСУГ-т хүргүүлээд байна.

-“Дээлтэй монгол” үйл ажиллагааг БАЗАН-ийн багш нар амжилттай зохион байгууллаа

-Сургуулийн эцэг эхийн зөвлөлөөс зохион байгуулсан “КАРАОКЕ” тэмцээнд 1-5-р ангийн эцэг эхчүүд идэвхтэй оролцон 2-р ангийн эцэг эхчүүд 2-р байр, 4-р ангийн эцэг эхчүүд 3-р байр тус тус эзэллээ.

1.24 Хүүхэд хамгаалалын багаас зохион байгуулсан “Ээждээ барих бидний бэлэг бүтээлийн уралдаанд 5-р анги ангиараа 1-р байр Бага ангийн сурагчдын төрөлд 3-р ангийн сурагч П.Болорчимэг 3-р байр, Б.Даваадорж 2-р байр 4-р ангийн сурагч Б.Ариунсанаа 1-р байр тус тус эзэлсэн.

1.25 Нийгмийн ажилтан 7, 8,10,12-р ангийн сурагчидтай болон нэр бүхий 3 сурагчидад ганцаарчилсан уулзалт зөвлөгөө өглөө .

1.26 Дотуур байрын”Сурагчдаа сонсох өдөр” өөр тэдний санаа бодлыг чөлөөт ярилцлагаар явуулж цаашид тулгамдаж буй асуудлаа гарган байрын зөвлөлийн үйл ажиллагаагаа эрчимжүүлэхээр чиглэл өглөө.

1.27 “Миний сайхан аав” зохион бичлэгийн уралдаанд нийт 20 гаруй захидал ирүүлсэн сурагчид аав хүний хамгийн сайхан эрхэм чанар халамж хайрын талаар сэтгэлийн нандин үгтэй захидал бичсэн байна

2. Сургалтын орчин сайжруулах чиглэлээр:

2.1 “Бүтээлч багш, ажилтан ” шалгаруулах 3 сарын аян зарлан сургуулийн орчны ногоон байгууламжийг нэмэгдүүлэх чиглэлээр хичээлийн байр, дотуур байранд цэцэг тарих үйл ажиллагааг эрчимжүүлж байна.

2.2 Бага ангийн багш нар өөрсдийн санаачлагаар STEM сургалтын танхимыг 240 мянган төгрөгөөр хамтран тохижуулж бага ангийн сурагчдын сэтгэх чадварын хөгжүүлэх сургалтыг хуваарийн дагуу зохион байгуулж байна.

2.3 Бага ангийн багш нар эцэг эхийн оролцоотойгоор сурагчдын бүтээлийн самбарыг 300,000 төгрөгний хөрөнгө оруулалтаар сурагчдын бүтээлийн самбарыг шинэчлэн сургалтын орчныг сайжрууллаа.

2.4 Дотуур байрны тохижилтонд багш ажилчид 1 өдрийн цалингаа хандивлан 2 давхарын вистүүлд 1 сая 600,000 төгрөгний буйдан, болон бусад зүйлсийг авч тохижуулав.

2.5 “Би хариуцлагатай аав,ээж” эцэг эхийн мэдээллийн самбар хийж өдөр тутмын мэдээллийг эцэг эхчүүдэд дамжуулж байна.

2.6 Шинэ дотуур байрын нээлтийн үйл ажиллагааг амжилттай зохион байгуулж Нээлтийн үйл ажиллагаанд Боловсрол, соёл шинжлэх ухаан спортын дэд сайд С.Ганбаяр, УИХ-ын гишүүн Д.Тогтохсүрэн аймаг, сум орон нутгийн удирдлагууд , албан байгууллагууд, эцэг эхчүүд нийт 200 гаруй хүн оролцлоо.

2.7 Ангиудын цэвэрлэгээ, тохижилт, эд аж ахуйн бүрэн бүтэн байдалд өдөр бүр хөндлөнгийн зүгээс хяналт тавьж, хариуцаж буй АУБ-нарт шаардлага тавих

2.8 1-9-р ангийн 105 хүүхэд шүдний үзлэгт хамрагдсан. Нийт сурагчдын эрүүл-45, эмчлэгдсэн-40, сувгийн эмчилгээ-20, буюу 80 орчим хувь нь эрүүлжсэн.

3. Хүүхдийн авъяас, сурлага хүмүүжлийн чиглэлээр:

3.1 Чөлөөт бөхийн хамтарсан сургалтанд Б.Алтанхуяг багштай 9 сурагч Бат-Өлзий суманд 10 хоног бэлтгэл хангаад ирсэн.

3.2 Бага ангийн STEM сургалтын тэмцээнд 2 багш 5 сурагч амжилттай оролцлоо.

3.3 ЭЕШ-д бэлтгэх тусгай төлөвлөгөө гарган ажиллаж байна. 12-р ангийн сурагчдыг ЭЕШ-д бэлтгэх зорилгоор сурагчдын амралтын дундуур Монгол-хэл, Англи-хэл, Хими-Биологи, Физик, Түүх-Нийгмийн Ухааны хичээлүүдээр тусгай хуваарийн дагуу хичээллэв.

3.4 Дээлтэймонгол”

аргахэмжээгзохионбайгуулах

Үндэсний уламжлалт оньсон тоглоом зааж, хүүхдүүд харилцан суралцлаа.

3.5 Цахим хэрэглээний журам зөвлөмжийн гангиудын буланд байрлуулан сурагчдад танилцуулсан

3.6 “Бид алдаагүй бичигтэн” “Бид цэвэр бичигтэн” аянуудыг үйл ажиллагааг чанаржуулж, Бүсийн массын олимпиадад бэлтгэх, амжилттай оролцохоор зорилго тавин ажиллалаа.

3.7 Монгол хэлний зөв бичгийн дүрмээр багш бүр сурагч, эцэг эхчүүдэд зориулсан гарын авлага гаргалаа.

3.8 “Монгол уламжлалт мэндчилгээний ёс - Дөрвөн улирлын мэндчилгээ” сэдвээр 2-5-р ангийн ах эгч нартаа танилцуулга мэдээлэл бэлтгэн танилцууллаа.

3.9 1-5-р ангийн “Ангийн номын сан”-г тохижуулах ажлыг хийж дуусгалаа. Анги бүр номын жагсаалтын дагуу ном хүлээн авч ангийн номын санг тохижуулан сурагчдаар ном уншуулах уншлагын цагийн хуваарь гарган номын тэмдэглэл хөтлүүлэх ажлыг зохион байгуулж эхлээд байна.

3.10 **Номын сан:** 1-5-р ангийн сурагчдын дунд хүүхдийн ой тогтоолт, унших чадварыг сайжруулах, ном унших дур сонирхлыг нэмэгдүүлэх зорилгоор “Хэн хамгийн сайн үлгэр ярих вэ” уралдааныг зохион байгуулж нийт 30 сурагч хамрагдсан.

- Сурагчид өдөр бүр уншсан номынхоо утгыг ярьж, 1-3-р сард нийт давхардсан тоогоор 76 сурагч ярьсан.
- 6-12-р ангийн сурагчдын дунд “Номын утга нь тэнгэр мэт агуу” илтгэлийн уралдааныг зохион байгуулж, 15 сурагч хамрагдсан бөгөөд сурагчдын өөрийгөө илэрхийлэх чадвар, уншиж судалсан байдал, бодит байдалтай нийцэж байгаа эсэхээр дүгнэлээ.
- 1-5-р ангийн сурагчид 100% номоор хангагдсан бөгөөд, 6-12-р анги 40 хувь хангагдсан.

4. Сургалт хэлэлцүүлэг зохион байгуулсан талаар:

4.1 Бага ангийн багш Н.Бямбадолгор, Б.Мягмарсүрэн, Л.Эрдэнэчимэг нарын “Байгалийн –Ухаан”-ны хэлэлцүүлэгт хичээлд дунд, ахлах ангийн багш нарын хамт сууж, санал дүгнэлт өглөө.

4.2 “Миний дотны найз” зохион бичлэгийн уралдаан” явуулж, сэтгэл ханамжийн судалгаа авсан 6-р ангийн сурагчдын дунд явуулж хамтач нөхөрсөг орчин бүрдэнэ.

4.3 “Үетэнгийнхний дарамт, шахалтаасурьдчилан сэргийлэх сэдэвт сургалт, хэлэлцүүлэгийг ба ангид зохион байгууллаа.

4.4 Дотуур байрын сурагчдыг шинэ дотуур байрны орчинтой танилцуулж орчны эрүүл ахуй, аюулгүй байдлын талаар санамж зөвлөмж сургалтыг явууллаа.

4.5 Монгол хэл, математикийн хичээлээр багш бүр массын олимпиадад бэлтгэх төлөвлөгөө гарган давтлагын хуваарь гарган хичээллэж байна. Давтлагын чанарт 7 хоног бүр шалгалт авч ахицыг тооцон ажиллахаар төлөвлөөд байна.

4.6 Багш бүр нэг хууль дүрэм судлан бусад багш нартаа сурталчилах ажлын хуваарь гарган хэрэгжүүлж байна. Энэ сард Багш Б.Мягмарсүрэн кабинетийн шинэчлэгдсэн журмаар бусад багш нартаа мэдээлэл өглөө.

4.7 БОЛОВСРОЛЫН ЧАНАРЫН ШИНЭЧЛЭЛ” сургуулийн тэтгэлэгт төсөл боловсруулах арга зүйн сургалтыг БСУГ-тай хамтран Уянга, Жаргалант, Туяа багийн 5 сургуулийн нийт 65 багш удирдах ажилтнуудыг хамруулан амжилттай зохион байгууллаа. Сургалтанд ЕБСургуулиудын захирал, нягтлан бодогч, бага ангийн багш нар хамрагдлаа.

5. Олимпиад, уралдаан тэмцээнд оролцсон байдал

5.1 Орос хэлний төрөлжсөн олимпиадын 2-ын даваанд П.Бундхорлоо багшийн бэлтгэсэн шавь 10а ангийн сурагч Б.Удвал 2-р байранд шалгарч мөнгөн медаль хүртсэн.

5.2 Хайрхандулаан суманд бүсийн хэмжээнд зохион байгуулагдсан өсвөрийн шатрын аварга шалгаруулах тэмцээнд 7а ангийн сурагч А.Мөнгөнсоёмбо мөнгөн медаль, 12а ангийн сурагч Д.Дагвадорж, Ж.Нарансолонго нар тусгай байранд шалгарсан.

5.3 Аймгийн өсвөрийн аварга шалгаруулах чөлөөт бөхийн тэмцээнд 7а ангийн сурагч А.Мөнгөнсоёмбо мөнгөн медаль, 8а ангийн сурагч С.Умбазар хүрэл медаль хүртлээ.

5.4 Химийн улсын төрөлжсөн олимпиадын 2-р шатанд С.Оюун-Эрдэнэ багшийн бэлтгэсэн шавь 12а ангийн сурагч Э.Мичидмаа мөнгөн медаль хүртлээ.

5.5 Дэлхийн усны өдөрт зориулан аймгийн БСУГ-аас зохион байгуулсан үйл ажиллагаагаараа тусгай байранд шалгарсан.

5.6 Монгол бичгийн төрөлжсөн олимпиадад Э.Даваа багшийн бэлтгэсэн шавь 12а ангийн сурагч Луу-Эрхбаяр 4-р байр эзэлсэн.

6. Эрүүл мэндийн чиглэлээр зохион байгуулсан ажил

6.1 Багш сурагчдын эрүүл мэндэд хяналт тавин, эрүүл мэндийн тусламж үзүүлэх шаардлагатай багш, ажилчид, сурагчдад анхны тусламж эмийн болон эмийн бус эмчилгээ хийсэн. Үйлчлүүлсэн багш 6 эмийн эмчилгээ-3 эмийн бус эмчилгээ-3

Үйлчлүүлсэн сурагч 19 эмийн эмчилгээ-17 эмийн бус эмчилгээ-2 Дуудлагаар дотуур байрны 5 хүүхдэд эрүүл мэндийн тусламж үзүүлж ажиллаж байна.

6.2 Дотуур байрны сурагчдын хоолны орц норм, илчлэг чанар, хадгалалт зэрэгт хяналт тавин 14 хоногт 1 удаа амталгаа хийж заавар зөвөлгөө өгч 2 тогоочтойгоо хамтран ажиллаж байна.

6.3 1-5-р ангийн сурагчдын үдийн цайнд хяналт тавин, сурагчдын гарын ариун цэвэр шалгаж сурагчидад болон анги удирдсан багш нарт заавар зөвөлгөө үүрэг даалгавар өгч ажиллаж байна.

6.4 1-12-р ангийн сурагчдыг “Чих хамар хоолой” үзлэгт нийт 195 хүүхэд хамрагдсан Эрүүл-150 Шүдний цооролттой-35

6.5 “Хараа шалгах” 1-12-р ангийн 203 Харааны өөрдлөлтэй-28 нүдний сул хараатай сурагчдыг 2 дахь шатны эмч БОЭТ-ийн их эмч Бямбасүрэнд үзүүлж зөвөлгөө авч нүдний шил зүүхийг зөвлөв.

6.6 “Өсвөр насны охид, хөвгүүд”-ийн урьдчилан сэргийлэх үзлэгт 67 сурагчыг хамруулсан. Эмчилгээ хийлгэх хүүхдүүдэд эм бичиж шаардлагатай хүүхдийг давтан шинжилгээ, эхо, ЗЦБ хийлгэн эмнэлэгт хэвтэх талаар зөвөлгөө өгөв.

6.7 “Дэлхийн усны өдөр”-ийн хүрээнд “ аха” танин мэдэхүйн тэмцээнийг 6-8-р ангийн сурагчдын дунд “ус ба эрүүл мэнд” сургалтын хүрээнд зохион байгуулсан.

6.8 6-8-р ангийн сурагчдын дунд “Ус ба эрүүл мэнд” 46 хүүхэд хамрагдсан “Гарын ариун цэвэр” 1-5-р ангийн сурагчидад мэдээлэл өгсөн “Бруцеллөз” “Менингокк” өвчнөөс урьдчилан сэргийлэх талаарх сургалтанд дотуур байрны 26 хүүхэд хамрагдсан.

6.9 Дотуур байрны сурагчдын эрүүл ахуйд хяналт тавин, 7 хоногт 2 удаа дотуур байрны сурагчдын ариун цэвэр шалгаж заавар зөвөлгөө өгч ажиллаж байна.

7. Эцэг эхийн зөвлөлийн үйл ажиллагаа 11 хүний бүрэлдэхүүнтэй байгуулан 36 заалт бүхий жилийн төлөвлөгөө гарган эхний

8. Хайрхандулаан суманд туршлага судалсан.

9. Хайрхандулаан сумын сурагчид ирж туршлага солилцсон

Нэмэлт ажлууд

10.Сумын байгаль орчны газраас зохион байгуулсан албан байгууллагуудыг сургуулийн болон дотуур байр, эзэмшил бүхий талбайн их цэвэрлэгээг хийж гүйцэтгэсэн.

11.Шинээр барьсан дотуур байрыг ашиглалтанд хүлээн авах бэлтгэл ажилд нийт багш ажилчдыг оролцуулан 1-өдөр их цэвэрлэгээ хийж ажилласан

12. “Эрүүл мэнд идэвхтэй хөдөлгөөн” сэдэвт мөсний баярыг нийт багш ажилчдын дунд 01-р сарын 25-ны өдөр “Хадан хошуу”ны гол дээр зохион байгууллаа.

13.17-р жарны “Урвуулагч “ хэмээх шороон гахай жилийн “Сар шинийн золголтоор ЗАН-үүдийн мэндчилгээ, /морь уралдуулах,шагай шүүрэх, гар бөмбөг”-ийн тэмцээнүүдийг зохион байгууллаа.

БАЗАН “Дээлтэй монгол өдөрлөг”-ийг сургуулийн захиргаатай хамтран зохион байгуулав

14.Эх орончдын өдөрт зориулсан “Гар бөмбөг”-ийн тэмцээнд 2-р байр, 3.8нд “Дэвжээ тэмцээн”-д 1-р байр, олон нийтийн ажил, хуралд хоцролгүй оролцож байна.

15.Эмэгтэйчүүдийн аварга шалгаруулах гар бөмбөгийн тэмцээнд 2-р байр, мөнгөн медаль

СУРГУУЛИЙН ЗАХИРГАА